

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ

эрдэм шинжилгээний бичиг

Боть XXXX (463)

2016

(93-107)

**“ЭХ ДҮР”-ИЙН ОНОЛООР ДУНДАД ЗУУНЫ МОНГОЛ ХЭЛНИЙ
ҮЙЛДЭГДЭХ ХЭВИЙГ ШИНЖЛЭХ НЬ
“Монголын нууц товчоо”-ны жишээгээр**

Шин Шин

Хураангуй

Танин мэдэхүйн хэл шинжлэлийн “эх дүр”-ийн онол(prototype theory) нь бидний ертөнцийн юм үзэгдлийг танин мэдэх болон анализ хийхэд нэгэн шинэ арга барилыг хангасан билээ. Дундад зууны монгол хэлэнд үйлдэгдэх хэвийн судалгаа эрдэмтдийн судалгааны нэг чухал сэдэв болсоор ирсэн бөгөөд судлаачид дундад зууны үйлдэгдэх хэвийн ангиллын талаар адил бусын үзэлтэй байсаар иржээ. Энэхүү бүтээлдээ танин мэдэхүйн хэл шинжлэлийн “эх дүр”-ийн онолд тулгуурлан “Монголын нууц товчоо”-нд “-Gd/-gd,-d/-t” бүтээврийн хэлбэржилтийн хэлбэр болон илтгэх утгыг задлан шинжилж үйлдэгдэх хэв нь дотроо эх дүр болон дэд гишүүд гэж хуваагдан тухайн айг бүрдүүлдэг байна гэх тогтолцоог илрүүлэхийг зорив. Энэ нь бидний дундад үеийн монгол хэлний үйлдэгдэх хэвийг ойлгон сурч эзэмшихэд улам дөхөм болно гэж үзэж байна.

Оршил

Дундад зууны дурсгалт бичигт “-Gd/-gd,-d/-t” бүтээвэр нь орчин цагийн монгол хэлэнд тодорхойлон заасан үйлдэгдэх хэвээс утга хэрэглээний талаар маш өргөн хэрэглэгдэж байв. Онцгойлон монгол туургатны соёлын гайхамшигт өв болсон “Монголын нууц товчоо”-нд үйлдэгдэх хэвийн хэрэглээ маш олон тохиолддог. Энэхүү өгүүлэлд голдуу “Монголын нууц товчоо”-ны баримт хэрэглэгдэхүүнд тулгуурлан танин мэдэхүйн хэл шинжлэлийн “эх дүр”-ийн онолын(prototype theory) үүднээс “Монголын нууц товчоо”-ны “-Gd/-gd,-d/-t” бүтээврийн хэлбэржилтийн хэлбэр болон илтгэх утгыг задлан шинжлэв.

Сонгодог монгол бичгийн өмнөх монгол бичгийн дурсгалд “-Gd/-gd,-d/-t” бүтээврийн хэлбэржилтийн тухай судлаач эрдэмтэд түүний хэлбэр бүтэц, илтгэх утгыг олохоор олон жил судалсаар иржээ. “-Gd/-gd,-d/-t” бүтээврийн тухай Поппе.И (1965), Doerfer.G (1966), Жирэньнигэ (1981,1992), Хүрэлбаатар (1985), Гарьд (1987), Чи.Сэцэн

(1996), Өлзий (2002), Сэцэнцогт (1992, 2012) зэрэг эрдэмтэд дундад эртний монгол хэлний үйлдэгдэх хэвийг судалсан бүтээлдээ “-Gd/-gd,-d/-t” бүтээврийн үйлдэгдэх хэвийн хэлбэржилтийг өгүүлбэрзүйн түвшинд хэлбэр ба утгын хувьд судлан шинжилж өөр өөрийн санаа оноогоо дэвшүүлсэн байдаг. Н.Н.Поппе “Монголын Нууц Товчоон дахь үйлдэгдэх хэв” (The Passive Construction in the Language of the Secret History) гэх бүтээлдээ үйлдэгдэх хэвийг *жинхэнэ идэвхгүй хэв* (The true passive), үйл хөдөлгөөнийг бусдын албадлага шахалт дор болон бололцоот байдал дор хийсэн *идэвхгүй хэв* (The passive of necessity and possibility), *шууд бус идэвхгүй хэв* (Indirect passive) гэж гурав ангилав. Гарьдаас *үйлдэгдэн хүртэх хэв* гэх нэр томъёог дурдаж, дундад зууны үеийн монгол хэлэнд “-гд” бүтээвэр үйлдэгдэх хэв болон үйлдэгдэн хүртэх хэвд багтана. “-д, -т” бүтээвэр голдуу үйлдэгдэн хүртэх хэвийн хэлбэрээр илэрч байжээ гэв. Сэцэнцогтоос “дундад зууны монгол хэлний үйл үгийн үйлдэгдэх хэвийг орчин цагийн монгол хэлнийхтэй харьцуулах нь” гэх бүтээлдээ дундад зууны монгол хэлний үйлдэгдэх хэвийг шууд үйлдэгдэх хэв ба шууд бус үйлдэгдэх хэв гэж хоёр хуваав. Мөн “Монгол хэлний үйл үгийн хэвийн онцлогийн тухай” гэх бүтээлдээ өмнө нь шууд бус үйлдэгдэх хэв (Сэцэнцогт, 1992), дам үйлдэгдэх хэв буюу үйлдэгдэн хүртэх хэв (Гарьд, 1987) гэж нэрлэж байсан хэлний илэрхийлэл нь эртний герег болон түрэг хэлний зүйн өөртөө үйлдэгдэх хэвтэй (middle voice) адилхан гэж өөртөө үйлдэгдэх хэв (middle voice) хэмээн нэрлэв. Энэ мэтээр үйлдэгдэх хэвийн айн талаар эрдэмтэд судлаачдын санал нэг мөр болоогүй байсаар.

Нэг. Үйлдэгдэх хэвийн тухай цогц ойлголт

Уламжлалт хэл шинжлэлд үйлдэх хэв болон үйлдэгдэх хэв бол тухайн үйлийг гүйцэтгэх хоёр эзэнд харьцах харьцаа заах үйл үгийн хэлбэр мөн гэж үздэг. Өгүүлбэрт өгүүлэгдэхүүн нь үйлийг үйлдэгч тохиолдолд үйлдэх хэвээр илэрхийлж, өгүүлэгдэхүүн нь үйлийг хүлээгч тохиолдолд үйлдэгдэх хэвээр илэрхийлдэг. Энэхүү хэв нь “-гд(-д, -т)” нөхцөлтэй. Жишээлбэл:

- а. Дайсан Доржийг алав.
- б. Дорж дайсанд алаглав.

а. өгүүлбэрт “дайсан” гэх өгүүлэгдэхүүн нь үйлийг үйлдэгч, “Дорж” гэх тусагдахуун нь үйлийг хүлээгч, иймээс энэхүү өгүүлбэр нь үйлдэх хэвт өгүүлбэр мөн. б. өгүүлбэрт “Дорж” гэх өгүүлэгдэхүүн нь “дайсан” гэх тусагдахууны үйлийг хүлээгч, “дайсан” гэх тусагдахуун нь үйлийг үйлдэгч болно, иймээс энэхүү өгүүлбэр нь үйлдэгдэх хэв мөн.

Үүсгүүр хэл шинжлэлд, Н.Чомскийн үзэхээр үйлдэгдэх хэвийн гүн бүтэц нь үйлдэх хэв, үйлдэгдэх хэв нь үйлдэх хэвээс улиран хувирч (passive transformation) ирсэн, жишээлбэл: англи хэлний үйлдэх хэвийн өгүүлэгдэхүүн болон тусагдахууны байрыг сольж, дараа нь “be, -ed” болон “by” зэрэг хэлзүйн илэрхийллээр тодруулах явдал болно. үйлдэгдэх хэв үйлдэх хэвээс улиран буй болсон, иймээс үйлдэгдэх хэвд “be, -ed” болон “by” зэрэг хэлзүйн илэрхийлэл нь ямар ч утга, үүрэг байхгүй хэлзүйн тэмдэг

(grammatical markers) мөн гэв.¹ Үүсгүүр хэл шинжлэлийн онолоор “Дайсан Доржийг алав” болон “Дорж дайсанд алагдав” гэх хоёр өгүүлбэр нь утгын талаар ялгаа байхгүй гэж үздэг.

Хүн төрөлхтний ертөнцийг танин мэдэх арга хэрэглүүр нь хүн төрөлхтний юм үзэгдэл, үйл хэргийн тухай цогц ойлголт (concept) болон хэлний илэрхийлэл, хэрэглээ болон хэлний тухай ойлголтыг шууд нөлөөлж байдаг. Хүн төрөлхтний танин мэдэхүйн зүй тогтолын зөрөө болон цогц ойлголтын адил бус байдал нь хэлнүүдийн хоорондох ялгааг бий болгож байдаг хэрэг юм. Ижил хэрэг явдлыг хүмүүний харах өнцөг, хандах хандлага болон танин мэдэхүйн арга хэрэглүүрээс шалтгаалан, хэрэг явдлын тухай ойлголт адилгүй бөгөөд хэрэг явдлыг илэрхийлэхдээ товойлгон ярих зүйл нь мөн ондоо байдаг, үүнээс болж адил бусын өгүүлбэрийн бүтэц буй болдог. Хүмүүсийн иймэрхүү харах өнцгөөс шалтгаалан адил бусын цогц ойлголт бий болгох үзэгдлийг Langacker “хагас аяга усаар” жишээ болгон тайлбарласан байдаг. Зураг мэт:²



Тайлбар:

№	Харах өнцөг	Өгүүлбэрээр илэрхийлбэл
a	Агуулах сав	the glass with water in it
b	Саван дах ус	the water in the glass
c	Аяганы хоосон хэсэг	the glass is half-empty
d	Аяганы устай хэсэг	the glass is half-full

Дээрх мэт хагас аяга усыг адил бусын өгүүлбэрийн бүтцээр илэрхийлсэн нь хүмүүсийн адил бусын танин мэдэхүйн бүтээх явцын (construal) хэлэнд илрэл болно. Дээрх танин мэдэхүйн процессоор үйлдэгдэх хэвийн гарал үүсэл, үйлдэх хэв болон үйлдэгдэх хэвийн харьцааны асуудлыг тайлбарлаж болох юм. Танин мэдэхүйн хэл шинжлэлийн үзхээр үйлдэх хэв болон үйлдэгдэх хэв нь хоёр ондоо утгыг илэрхийлдэг хэлний ай мөн. Жишээлбэл: “Дайсан Доржийг алав” болон “Дорж дайсанд алагдав” гэх үйлдэх хэв болон үйлдэгдэх хэвийн өгүүлбэрт авч хэлбэл, үйлэнд оролцогч үйлийг хүлээгч “Дорж” болон үйлийг үйлдэгч “дайсаны” аль нэгний нь өнцгөөс авч үзэхээс шалтгаалан адил бусын өгүүлбэрзүйн бүтэц буй болов. Үйлдэгдэх хэв нь үйлийн хүлээгч болон үйлийн үйлдэгчийн алийг нь довойлгох үүрэгтэй буй гэх асуудал дээр судлаачид ерөнхийдөө гурван үзэлт байдаг. 1) Үйлдэгдэх хэв нь үйлийг хүлээгчийг довойлгох үйлдэлтэй. 2)

¹ Chomsky, N (1957), Syntactic Structures [M]. The Hague: Mouton, p. 61.


² Langacker Ronald (2008), Cognitive Grammar: A Basic Introduction [M]. New York: Oxford University Press, p. 43-44.

Үйлдэгдэх хэв нь үйлийн үйлдэгчийг довойлгох үйлдэлтэй. 3) Үйлдэгдэх хэв нь үйлийг хүлээгч болон үйлдэгчийн алийг нь довойлгох тухай бодит хэлний орчин даруй өгүүлэмжээс тогтоогдоно. Өгүүлбэрийн бүтцийн талаар танин мэдэхүйн хэл шинжлэлийн үзэхээр үйлдэгдэх хэв нь үйлдэх хэвээс буй болсон биш, “be , -ed” болон “by” зэрэг хэлзүйн илэрхийлэл нь үйлдэгдэх хэвийн утга зүйн бүтцэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж үздэг.

Хоёр. “Эх дүр”-ийн айчлах онол

Хүн төрөлхтний юм үзэгдлийг төрөл зүйлд хуваах сэтгэл зүйн үйл ажиллагааны явцыг айчлах(categorization) гэнэ.³ Хүмүүн бүхэн нялх хүүхдийн үеэс эхлэн айчлалын дунд нийгэм, ертөнцийн түмэн бодистой танилцдаг. Хэл шинжлэлийн категоржиллолтод хоёр талын агуулга байдаг. Нэг нь хүн төрөлхтөн хэлээр дамжин орчлон ертөнцийн оршихуй обьёоктод төрөл зүйл хуваах явц, нөгөө нэг агуулга нь хэл шинжээчид хэлэнд төрөл зүйл хуваах явц. Жишээлбэл: эгшиг, гийгүүлэгч, бүтээвэр, нэр үг, үйл үг зэрэг ухаагдахуун бол бүр хэлэнд төрөл зүйл хуваасан үр дүн мөн. Танин мэдэхүйн үүднээс харвал, айчлах бол хүн төрөлхтний ертөнцийн түмэн бодисын шинж чанар, хэлбэр дүрс, үүрэг зэргийн дундаас адилавар талыг олж харан, зүйчлэн нэг төрөлд багтаан ухаагдахуун бүрэлдүүлэх явц болон чадвар мөн, үүнийг танин мэдэхүйн хэл шинжлэлд “танихуйн ай”(cognitive categorization) буюу “цогц ойлголтын ай”(concept categorization) гэдэг.

Үүнд ерөнхийдөө голдуу гурван зүйлийн айчлах арга байдаг: Аристотелийн уламжлалт айчлах арга (the classical theory of categories), Виттгенштэйнгэр бүлийн төсөөтэй онол (family resemblancetheory) болон танин мэдэхүйн хэл шинжлэлд “эх дүр”-ийн айчлах онол (prototype theory). Зургаар илэрхийлбэл:



(1) Уламжлалт айчлах арга: Аристотелийн уламжлалт айчлах аргын үзэхээр ямар нэгэн айд багтаах гишүүд нь шаардлагатай гүйцэт шинж чанарыг хангасан байх хэрэгтэй, гишүүдийн хооронд адил тэгш харьцаатай бөгөөд хоёр айн хооронд ил тод зааг хязгаартай байдаг.⁴

³ Ungerer, F.; H.J.Schmid (2001), An Introduction to Cognitive Linguistics [M]. Beijing Foreign Language Teaching and Research Press, p. 2

⁴ Taylor, John R (2003), Cognitive models of Polysemy. In Polysemy: Flexible Patterns of Meaning in Mind and Language[J] (ed.) by Brigitte Nerlich , Zazie Todd , Vimala Herman , David D. Clarke. Berlin; New York: Mouton de Gruyter. p. 31-47

(2) Гэр бүлийн төсөөтэй онол: Виттгенштэйнгэр бүлийн төсөөтэй онолын үзэхээр нэг айн гишүүдийн хооронд ямар нэгэн хэлбэр буюу шинж чанараар хоорондоо харьцаатай байдаг. Гэвч энэхүү айг тодорхойлох нийтийн онцлог бүгдэнд нь зэргээр байхгүй.⁵ Виттгенштэйн тоглоомын айгаар жишээ татан тайлбарлав.

(3) “Эх дүр”-ийн айчлах онол: 1975 онд Элеонор Рош(Eleanor Rosch) болон түүний хамт ажилтан Виттгенштэйн гэр бүлийн төсөөтэй онолын суурь дээр “эх дүр”

(prototype) гэх тодорхойлолтоор анх хүн төрөлхтний айчлах явцыг тайлбарласан

байдаг. “Эх дүр”-ийг (prototype) ямар нэгэн айн “үлгэр загвар” гэж тодорхойлов.⁶

“Ай” нь аливаа юм үзэгдлийн ухагдахууныг таних боломж олгохын зэрэгцээ түүний төлөөлөл болох эх дүрийг гаргах үйл явц танихуйн нэг чухал үйл явц юм. Эх дүрийг

тойрон айчлах үйлийг “эх дүр”-ийн онол (prototype) гэнэ.⁷ Айчлах онолын үзэхээр ай

нь нэг хэсэг төсөөтэй гишүүдээс бүрэлдэх бөгөөд “эх дүр” нь энэхүү ай дах хамгийн үлгэр загвар болхуйц гишүүн мөн, бусад гишүүд нь адил бус хэмжээний “эх дүр”-ийн шинжтэй, ай дах гишүүд нь энэ мэтээр адил бус байр суурьтай байдаг. Ай нь “эх дүр”-ээр голлосон тойрог хэлбэртэй, төвөөс алслах тутам тухайн эх дүрийн шинж багасана. Жишээлбэл, шувууны айн хувьд бор шувуу, тагтаа зэрэг нь “эх дүр”-д багтан, тэмээн хяруул, оцон шувуу зэрэг нь дэд гишүүдэд багтана.

Гурав. Дундад зууны монгол хэлний үйлдэгдэх хэвийн “эх дүр” болон дэд гишүүд

“Эх дүр”-ийн онолоор монгол хэлний үйлдэгдэх хэвийг үйлдэгдэх хэвийн “эх дүр” болон дэд гишүүд гэж хувааж болно. “Эх дүр” нь энэхүү ай дах гол төлөөлөл болсон хүний оюун ухаанд амархан буудаг, бусад гишүүдээс ялгарах тодорхой шаардлагыг хангасан хамгийн үлгэр загвар болхуйц гишүүн мөн. Дор үйлдэгдэх хэвийн бүтэц хэлбэр болон утгыг үндэслэн “эх дүр” болон дэд гишүүд гэж хуваав.

1. үйлдэгдэх хэвийн “эх дүр”

“Эх дүр”-ийн онолд суурилж үйлдэгдэх хэвийн бүтэц хэлбэр болон утгыг үндэслэвэл, үйлдэгдэх хэвийн хэлбэр бүтцийн хувьд, хэлний зүйн өгүүлэгдэхүүн нь үйлийг шууд хүлээгч бөгөөд нэрлэхийн тийн ялгалаар хэлбэржиж, үйлийг үйлдэгч нь

⁵ Rosch, E., Mervis, C. B (1975), Family resemblances: Studies in the internal structure of categories[J].Cognitive Psychology. p. 573-605.

⁶ Ungerer, F.; H.J.Schmid (2001), An Introduction to Cognitive Linguistics [M]. Beijing Foreign Language Teaching and Research Press, p. 12.

⁷ Н.Нансалмаа ; С.Долгор (2014), Танихуйн хэл шинжлэл[М], УБ: Соёмбо принтинг. р. 191.

өгөх оршихын тийн ялгалаар хэлбэржиж, өгүүлэхүүн гишүүн нь тусах үйл үгээс “-Gd/-gd,-d/-t” бүтээврээр хэлбэржсэн бүтцийг үйлдэгдэх хэвийн “эх дүр” гэнэ. Үйлдэгдэх хэвийн “эх дүр” нь доорхи мэт хоёр хувилбар буй:

①

a. үйлийг хүлээгч-NOM + үйлдэгч + dative + vt-PASS

qorci-noyan quduqa-beki qoyar tumat-ta bariqdaju (MHT, §241)

b. үйлийг хүлээгч-NOM + үйлдэгч + dative + vt-PASS + үйлийг хүлээгч

qan ecige minu qaljirqu-yū gü'ün-e qatquqdaba ci (MHT, §177)

c. үйлдэгч + dative + vt-PASS + үйлийг хүлээгч

tatar irgen-e bariqda'a bi (MHT, §53)

② үйлийг хүлээгч + vt-PASS

belgütei teyin cabciqdaju (MHT, §131)

2. Үйлдэгдэх хэвийн дэд гишүүд

(1) Үйлдэгдэх хэвийн дэд гишүүдийн буй болсон шалтгаан

“Эх дүр”-ийн ай нь “Эх дүр”-ийг тойрсон дэд гишүүдээр бүрэлдсэн “цацраг айг”(radial category) буй болгодог, ай дахь “эх дүр” нь дэд гишүүдтэй ямар нэгэн нийтлэг шинжтэй байдаг. “Эх дүр” нь хүний анхны танин мэдэж, ойлгож авсан цөм дүр байдаг, Дэд гишүүд нь метафороор дамжин буй болж, “эх дүр”-ийн тойронд өргөсөн хөгжиж айн цар хүрээг тэлдэг. Танихуйн үйл дэх метафорийн үндсэн үүрэг нь нэгэнт байгаа айг хүний туршлагад суурилан дэлгэрүүлэн хөгжүүлдэг явдал болно. Бид “явах” гэх үгийг авч үзье. “Явах” гэх үгийн үндсэн утгыг “Монгол Хэлний Их Тайлбар Толь”-д “Хүн, амьтны алхах, зорчих, одох” гэх утгатай гэж тайлбарлав. Энэ нь “явах” гэх үгийн “эх дүр” мөн. Хүн амьтны нэг орон зайгаас нөгөө орон зайд шилжих хөдөлгөөнийг заадаг “явах” гэх үгийг мефорчилон “үйл явдлыг эрхлэн гүйцэтгэх”, “үйл явдал цаг хуцааны хувьд үргэлжлэх” гэх мэтийн шилжсэн утга бүхий дэд гишүүд үүсэн “эх дүр”-ийн тойронд буй болов. Жишээлвэл:

➤ МАН-тай МАН-гүй төрийн ажил явж л байна.

➤ Цэргийн үүрэгтний бүртгэл ажил 50.2 хувьтай явж байна.

➤ Ч.Сайханбилэг: АСЕМ-ын бэлтгэл ажил явж байгаа. Сайн зохион байгуулна.

➤ Муу яригдаж байж ажил явдаг байхгүй юу гэх мэтээр хэрэглэгдэж байгаа. “явах” гэх үгийн үйлдэгдэх хэвийн хэрэглээ нь өөрөө үйлдэх хэвийн хэрэглээгээс илүү өргөн

хэвчээтэй байдаг. Жишээлбэл:

- Сургалт явагдаж байна.
- Ажил явагдаж байна.
- Бүртгэл явагдаж байна.
- Урамшуулалт худалдаа явагдаж байна.
- Тэмцээн явагдаж байна.
- Хурал явагдаж байна гэх мэт.

М.Саруул-Эрдэнээс “Монгол монголоороо үлдэхэд хэлний дархлаа чухал” гэх илтгэлдээ Орос хэл монгол хэлэнд маш их нөлөөлж байсан үед “хурал явагдаж байна”, “тэмцээн явагдаж байна” гэсэн хэллэг бий болсон. Энэ нь монгол үгзүйн маш чухал зүй тогтлыг зөрчсөн үг байгаа юм. Монгол хэлэнд хэзээ ч эс тусах үгэнд “-гд” нөхцөл залгадаггүй байна. Орос хэлэнд хурал цуглааныг “идёт” гэдэг үгээр хэлдэг. Түүнийг нь махчлан орчуулж “явж байна” гэж хэлж болохгүй, нөгөөх нь амьд яваад байгаа юм шиг болонгуут манайхан эх хэлнийхээ дүрмийг зөрчин эс тусах үйл үгэнд үйлдэгдэх хэвийн нөхцөл залгаад “явагдах” гэж үг бий болгожээ⁸ гэв. Утгын хувьд бид “явж” гэх үгийн хэрэглээний утгыг авч үзвэл, “ажил явж байна” болон “ажил явагдаж байна” гэх өгүүлбэр дэх “явж” болон “явагдаж” гэх үг нь энд бүр “үргэлжилж” гэх утгаар хэрэглэгдэв. Орон зай дахь нэг цэгээс нөгөө цэгт хүрэх хөдөлгөөнийг цаг хугацаа дахь үйл явдлын үргэлжлэлийг метафорчлон заах болов. Ажил өөрөө явдаггүй боловч бид танинхуйн туршлагад түшиглэн “ажил явж байна” гэдгийг ойлгон хүлээж авдаг. Үүнд “явагдах” гэх үйлдэгдэх хэвийн хэрэглээ нь харьцангуй илүү байх нь ажил өөрөө бие даан үргэлжлэх биш, харин хэсэг бүлэг хүмүүс түүнийг зохион байгуулж удирдаж явуулдаг. Гэхдээ энэ хүмүүсийг дурьдах шаардлагаа байхгүй, үйлийг хүлээгч ажил нь гол сэдэв (topic) болж байгаа учир энд үйлдэгдэх хэвийн бүтээврээр дээрх утгыг илэрхийлсэн байдаг. Өгүүлбэрийн бүтцийн талаас авч үзвэл, хэлний зүйн өгүүлэгдэхүүн нь үйлийг шууд хүлээгч бөгөөд нэрлэхийн тийн ялгалаар хэлбэржиж үйлдэгдэх хэвийн үндсэн шинжтэй нийцэж байгаа учир бид “явагдах” гэх үгийг үйлдэгдэх хэв мөн гэж авч үзэх нь зүйтэй. Түүхийн хэл шинжлэлийн үүднээс, “Монголын нууц товчоо”-нд эс тусах үйл үгэнд үйлдэгдэх хэвийн бүтээвэр залгадаг илэрхийлэл олон тохиолддог бөгөөд “явагдах” гэх үг “Монголын нууц товчоо” болон XIII-XVI зууны үеийн дурсгалт бичигт хэрэглэгдсэн байдаг.

- cima-lu’a minqalaju eyetüldüjü yabuqdaq ke’eba (MHT, §209)
- sim-müren-e güртеle hüldejü yabuqdarun (MHT, §257)
- tngri-yi:n urtu-da oroSiqu Gajar-un nayi:raGu:lun öskekü irgen-U nasu aburid-ta yabuGdaq yabudal bolu (Taq. The Mongolian Version of Hsiao-ching, 11a., 3.)⁹

⁸ <https://ehhelbichig.wordpress.com/2010/06/18/м-саруул-эрдэнэ-монгол-монголоороо-үл/>

⁹ D.Tumurtogoo (2006), The Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII-XVI Centuries): Introduction, Transcription and Bibliography[M]. Taipei, Taiwan: Institute of Linguistics, Academia Sinica. p.108

- [02b] Dege:dU arSi-nar-a yabuGdaGsan teyi:mU oron-dur asuru sayi:tur oroSin saGu:ju sacalal Ugei ilaGu:Gsad-un (Bur. The Mongolian Version of the “Twelve Deeds of Buddha”, p. 108)

Дээрх мэтээр “явах” гэх үгийн үйлдэгдэх хэвийн хэлбэржилт “Монголын нууц товчоо” болон XIII-XVI зууны үеийн дурсгалт бичигт байх баримтаас бид мэдэж болох нь “явагдах” гэх үг нь эх хэлний дүрмийг зөрчин эс тусах үйл үгэнд үйлдэгдэх хэвийн нөхцөл залгасан биш, “хурал явагдаж байна”, “тэмцээн явагдаж байна” гэх хэрэглээ нь “Хүн, амьтны алхах, зорчих, одох” гэх утгатай “явах” гэх үгийн метафорчилсон хэрэглээ. “явагдах” гэх эс тусах үйл үгийн үйлдэгдэх хэвийн хэрэглээ эртнээс байсан, хүмүүний танихуйн явцын дүрэм горимоор хэрэглээ нь өргөжин тэлсэн гэх дүгнэлтэд хүрч болно.


(2) Эс тусах үйл үг үйлдэгдэх хэвээр хэлбэржих тухай

Энэ мэтээр монгол хэлний эс тусах үйл үг үйлдэгдэх хэвээр хэлбэржих эсэх талаар эсрэг тэсрэг санал гарсаар байгаа. Дор бид Гарьд болон Сэцэнцогтын дурьдсан үйлдэгдэн хүртэх хэв болон өөртөө үйлдэгдэх хэвийн (middle voice) тухай задлан шинжилж, эс тусах үйл үгийн дараа залгасан “-Gd/-gd,-d/-t” бүтээвэр нь үйлдэгдэх хэвийн бүтээвэр мөн, үйлдэгдэх хэвээс гадна үйлдэгдэн хүртэх хэв болон өөртөө үйлдэгдэх хэв гэж ангилах нь зохисгүй, харин үйлдэгдэх хэвийг дотор нь “эх дүр” болон дэд гишүүд гэж ангилах нь түүхийн үүднээс монгол хэлнийхээ онцлогийг танин мэдэх, эзэмшихэд ихээхэн ач холбогдолтой гэх дүгнэлтэд хүрвэ.


Үйлдэгдэн хүртэх хэвийн тухай

Гарьдаас “Дундад зууны үеийн монгол хэлэнл дах -qda/-qde~ -da/-de хэлбэр” гэх бүтээлдээ үйлдэгдэн хүртэх хэв гэх нэр томъёог дурьдав. Үйлийг хүлээгч этгээдээ үйлийг үйлдэгч этгээдээс орон байрлалын талаар ойрчлон хэлэх (бичих) хэвийн айг үйлдэгдэн хүртэх хэв гэнэ. Даруй үйлийг хүртэн хүлээгчээ ойрчлон хэлсэн явдал юм. Дундад зууны үеийн монгол хэлэн дэх “-гд” дагавар үйлдэгдэх хэв болон үйлдэгдэн хүртэх хэвийн хэлбэр болж, “-д, -т” дагавар голдуу үйлдэгдэн хүртэх хэвийн хэлбэр болж байжээ гэв. Үйлдэгдэн хүртэх хэв гэгч бол хэлэгдэгч этгээд өөр бусдаас ямар нэгэн холбогдсон үйл үйлдэгдээд, тэрхүү үйл нь холоос ойр чиглэлтэйгээр хүртэн олж бүхий утгыг хэлбэрээр илтгэсэн, даруй үйлийг хүртэн хүлээгчээ ойрчлон хэлсэн явдал юм. Тус хэвийн утга нь орчин цагийн монгол хэлэнд нэгэнт байхгүй болсон байж, үйлдэгдэх хэвтэй нийлж нэгтсэн юм гэв.¹⁰ Мөн үйлдэгдэх хэв болон үйлдэгдэн хүртэх хэвийн үйлийг үйлдэгч болон үйлийг хүлээгчийг нэгдүгээр бие, хоёрдугаар бие, гуравдугаар биетэй холбон тайлбарлаж, түүний үйл хүртээлийн харьцаа нь зураг мэт гэв.

¹⁰ Garudi(1987), Dumdadu jaGun-u üy-e-yin mongGol kelen deki -qda/-qde~-da/-de kelberi. MKUJ:3. p. 36-38.



Үйлдэгдэх хэвийн үйл хүртээлийн харьцаа



Үйлдэгдэн хүртэх хэвийн үйл хүртээлийн харьцаа

Үйлдэгдэн хүртэх хэвийн тодорхойлолтоос авч үзвэл, үйлдэгдэн хүртэх хэв нь үйлийг хүлээгч этгээдээ үйлийг үйлдэгч этгээдээс орон байрлалын талаар ойрчлон хэлэх(бичих) хэвийн айг үйлдэгдэн хүртэх хэв гэнэ, даруй үйлийг хүртэн хүлээгчээ ойрчлон хэлсэн явдал мөн гэв.

Үйлийг хүртэн хүлээгчээ ойрчилон хэлсэн явдал бол үйлдэгдэх хэвийн чухал нэгэн онцлог мөн. Судлаачид үйлдэгдэх хэв нь үйлийг хүлээгч болон үйлдэгчийн алийг нь довойлгох тухай маргаантай байдаг. Нэг хэсэг судлаачид үйлийг хүлээгчийг довойлгох үйлдэлтэй гэж үздэг. Энэ нь үйлдэгдэн хүртэх хэвийн тодорхойлолтын үйлийг хүлээгчээ ойрчлон хэлэх гэсэнтэй адилхан байна. Иймээс үйлдэгдэн хүртэх нь үйлдэгдэх хэвээс чанарын талаар ямар нэгэн ялгаа байхгүй. Мөн үйлдэгдэх хэвийн үйлийг үйлдэгч болон үйлийг хүлээгчийн нэгдүгээр бие, хоёрдугаар бие, гуравдугаар биеэр хэлбэржих нь үйлдэгдэх хэвтэй шууд холбоотой биш учраас энэ нь мөн үйлдэгдэх хэв болон үйлдэгдэн хүртэх хэвийн ондоо тал болж чадахгүй. Энэхүү бүтээлдээ бид үйлдэгдэх хэв нь үйлийг хүлээгч болон үйлдэгчийн алийг нь довойлгох тухай бодит хэлний орчин даруй өгүүлэмжээс тогтоогдоно гэх үзэлтийг хүлээн зөвшөөрч байна.

Дор судлаачийн энэхүү бүтээлдээ татсан үйлдэгдэн хүртэх хэвийн нэгэн жишээг задлан шинжилж үзье.

➤ ede qurban merkit erten-ü hö'elün-eke-yi ciledü-daca buliju abdala'ai ke'en(МНТ,§102)

Энэхүү үйлдэгдэн хүртэх өгүүлбэрт, үйлийг шууд хүлээгч нь Өгэлүн эх, үйлийг шууд бус хүлээгч нь Чилэдү болон гурван Мэргид, үйлийг үйлдэгч нь Есүхэй баатар. Хэрвээ шууд үйлийн шууд хүлээгч болох Өгэлүн эхийг ойрчлон хэлсэн явдал гэж жишвэл, энд зохиогчоос шууд өөрөө үйлдэх хэвээр “Өгэлүн эхийг, Чилэдүгээс булааж авлаа хэмээн” гэж илэрхийлсэн ч болно. Энд Өгэлүн эхийг тодотгон зааж байгаа нь үйлдэгдэн хүртэх хэвийн бүтээвэр биш, харин заахын тийн ялгал мөн. Үйлдэгдэх хэвийн бүтээврийн энэхүү өгүүлбэр дэх үүргийг бид өгүүлэмжийн түвшнээс харвал, гурван Мэргид Өгээлүн эхийг Есүхэй баатарт булааж автсан гэх санааг илэрхийлсэн үйлдэгдэх хэв мөн, өөрөө үйлдэх хэвээр илэрхийлсэн ч бид тухайн хэлний орчинд

ойлгох боловч, дундад зууны монгол хэлэнд үйлийг хүлээгч болон үйлийг үйлдэгчийг маш нарийн ялгаж, үйл үгэнд заавал үйлдэгдэх хэвийн марк хийж байсныг бид “Монголын нууц товчоо”-ны эх болон орчин цагийн монгол хэлэнд буулгасан “Монголын нууц товчоог” харьцуулвал олж харж болно.

➤ *erten-ü hö'elün-eke-yi ciledü-daca buliju abdala'ai ke'en*(МНТ,§102)

Чилэдүгээс Өэлүн эхийг булааж авсны өшөөг нэхэхээр ирсэн ажээ.
(Ц.Дамдинсүрэнгийн орчуулга)

Гарьдаас мөн энэ бүтээлдээ, “хурал явагдаж байх, ажил сайн явагдах” гэх мэтийн ахицын хэмжээнд холбогдон яригдаад “алхах, очих” гэх мэтийн утгаар хэрэглэгдэдэггүй, “суух” гэх үг нь мөн адилхан бодит утга байхгүй. “Биелэгдэх” гэх үгийн үндэс болж байгаа “биелэ-” нь энгийн байдалд үйлдэгдэх хэвээр хэлбэрждэг бусад үгийн үндэс шиг биеэ дааж өгүүлбэрт орох бололцоогүй идэвхигүй үндэс. Иймээс “явагдах, суугдах, биелэгдэх, элэгдэх” зэрэг үгэнд байгаа “-гд” хэлбэр нь орчин цагийн монгол хэлэнд үйлдэгдэх хэвийн дагавар гэж магадлаж хэлэхэд арай баримт мөхөсдөх нь илэрхий гэж дурьджээ. Иймээс дээрхи байдалд суурилан жинхэнэ үйлдэгдэх хэвийн “-гд” дагавар бол тусах үйл үгэнд хэлбэрждэг гэж бид үзнэ. Эс тусах үйл үгэнд хэлбэржсэн “-гд” хэлбэрийг үйлдэгдэх хэв биш гэв.(P31-32) Мөн Ч.Сэцэнээс “Монгол хэлний үйлдэгдэх хэвд гарсан гурван хувиралт” гэх бүтээлдээ, эс тусах үйл үгийн үйлдэгдэх хэвийн хэлбэржилт нь одоо үеийн монгол хэлний зарим дүрэмтэй яг эсэргэцэлдэх газар буй. Тухайлбал үйлдэгдэх хэвт үйл үг нь өмнөө заахын тийн ялгалт үгийг захирч чадахгүй, тусагдахуун нь заахын тийн ялгалаар хэлбэржиж болохгүй. “-гд” дагаварыг тусах үйл үгийн дараа залгаад тусах үйлийг эс тусах үйл болгодог.¹¹ Олон хэлний хэв шинжээс авч үзвэл, эс тусах үйл үгийн үйлдэгдэх хэвээр хэлбэржих үзэгдэл ганц монгол хэлэнд байгаа биш, орос, герман, голланд, япон зэрэг маш олон хэлэнд бүр байдаг. Орчин цагийн монгол хэлний эс тусах үйл үг үйлдэгдэх хэвээр хэлбэржих тухай нөлөө бүхий эрдэмтэд мөн хүлээн зөвшөөрдөг. Ш.Лувсанвандангаас “-гд” дагаврыг “яв” гэсэн эс тусах үйл үгэнд залгах тохиолдол буй гэв.¹² В.Л.Котвич, “Алтай хэлнүүдийн судлал”(1953) гэх бүтээлдээ эс тусах үйл үгийн үйлдэгдэх хэвийн хэлбэржилт “Монгоолын Нууц Товчоонд” маш олон харагдах бөгөөд орчин цагийн халимаг хэлэнд ч хэрэглэгддэг.¹³ Г.Д.Санжеев “Монгол хэлнүүдийн харьцуулсан хэлзүй” хэмээх бүтээлдээ эс тусах үйл үгийн үйлдэгдэх хэвээр хэлбэржих тухай “явах, хоцрох, хаах, мэдэх” зэрэг үгээр жишээлэн дурьджээ.¹⁴ Чингэлтэйгээс цөөхөвтөр эс тусах үйл үгэнд

¹¹ Ч.Сэцэн (1996), Монгол хэлний үйлдэгдэх хэвд гарсан гурван хувиралт. Монгол хэл бичиг. Хөххот. р.30

¹² Ш.Лувсанвандан (2010), Орчин Цагийн Монгол Хэл. УБ., р. 301.

¹³ (波)W. 科特维奇著 (2004), 哈斯译.阿尔泰诸语言研究. 内蒙古教育出版社. р.173.

¹⁴ Г.Д.Санжеев (1963), Монгол хэлнүүдийн харьцуулсан хэлзүй, Москва.

залгаж мөн эс тусах үйл үгийн үндсийг бүтээнэ гэжээ. “Явагд, суугд” гэх жишээ татав.¹⁵

Өөртөө үйлдэгдэх хэвийн тухай

➤ * [үйлийг үйлдэгч-NOM] + үйлийг хүлээгч-ACC-GEN + Vi-PASS

edö'e kö'ü-ben üjejü mawui setki'esü ene metü cisu-ban qarqaqdasu ke'en(МНТ, §178)

Сэцэнцогтоос “Монгол хэлний үйл үгийн хэвийн онцлогын тухай” гэх бүтээлдээ “Иймэрхүү эс тусах үйл үг үйлдэгдэх хэвээр хэлбэржих хэрэглээг өөртөө үйлдэгдэх хэв (middle voice) гэж нэрлэв. Өөртөө үйлдэгдэх хэвийг зарим эрдэмтэд үйлдэгдэн хүртэх хэв(Гарьд), шууд бус үйлдэгдэх хэв буюу дам үйлдэгдэх хэв(Цэцэнцогт) гэдэг гэв. Өөртөө үйлдэгдэх хэв (middle voice) бол эртний герег хэлний зүйд байдаг нэг төрлийн өгүүлбэр, өөртөө үйлдэгдэх хэв бол өгүүлбэрт илтгэж бүхий үйл хөдөлгөөн бол түүний тус биед нь хүртсэн байдаг эсвэл тэр хөдлөл нь тухайн хүний тус биед чиглэгдсэн байдаг.¹⁶ Эс тусах үйл үгэнд ердөө үйлдэгдэх хэвийн дагавар залгадаггүй. Орчин цагийн монгол хэлэнд иймэрхүү үйлдэгдэх хэвийг эртний монгол хэлний ёсоор зөв оновчтой илтгэж чадахгүй зөвхөн өөрчлөн илтгэж болногөж дурьджээ.¹⁷ Өөртөө үйлдэгдэх хэвийн (middle voice) олон хэлэн дэх судалгаанаас харвал, өөртөө үйлдэх хэв (middle voice) гэх нэр томъёоны тухай хоёр зүйлийн тайлбар байдаг. Нэг нь эртний герег хэлэн дэх үйл үгийн нэг зүйлийн хэлбэр. Эртний герег хэлний өөртөө үйлдэгдэх хэвд үйлийг үйлдэгч нь өөрөө үйлийг хүлээгч буюу өөрийн ашиг тусын тул өөрөө хийсэн гэх утгыг илтгэдэг үйлийг заадаг,¹⁸ нөгөө нэг тайлбар нь Lyons-ийн дурьдсан утга зүй дэх тодорхойлолт мөн, даруй өгүүлэгдэхүүнийг нөлөөлөх үйл (action) буюу байдлыг (state) заана.¹⁹ Иймээс өөртөө үйлдэгдэх хэвийн (middle voice) бүтэц хэлбэрийн талаар мөн нэгэн нэгдэлтэй ойлголтонд хүрч чадаагүй байсаар.

Дээрх Ван ханы хэлсэн үгийг задалвал: “Энэ мэт цусаа гаргагдасу” гэх үгийг Жачцэцэнээс “**就和我这血一样，被他人（刺）出** (бусад хүмүүнд энэ мэт цусаа

гаргагдаж үхье)” гэж орчуулан, эртний монголын заншил болон бөөгийн шашинд цус урсан үхвэл, сүн нь зовлон амсдаг гэж үздэг. Жамуха Чингис хаанаас цус үл гарган алахыг гуйсан ба Чингис хаан Жамухыг цус үл гарган нөгчөөж билээ, одоо ч гэсэн “цусаар үхэхсэн” гэх үг бол хамгийн муухай хараал зүхлийн үг байдаг гэж тайлбарлав.²⁰

¹⁵ Чингэлтэй (2010), Одоо үеийн монгол хэлний зүй, Хөххот. p. 328.

¹⁶ R.R.K. Hartmann & F.C. Stork (1972), Dictionary of Language and Linguistics (Хятад орчуулга). London: Applied Science Publishers, p. 380.

¹⁷ Сэцэнцогт (2012), Монгол хэлний үйл үгийн хэвийн онцлогын тухай, Олон улсын монголч эрдэмтний Х их хурал, УБ. p. 239-240.

¹⁸ Kemmer; Suzanne (1993), The Middle Voice[M].San Diego : John Benjamins Publishing Company. p.1.

¹⁹ Lyons, J (1969), Introduction to Theoretical Linguistics, Cambridge University Press. p. 373.

²⁰ 札奇斯欽 (1979), 《蒙古秘史》新譯並註釋 台北:聯經出版社 p. 236.

Үйл хэргийн өрнөлтийн үр дүнд Ван хан Найманы харуул Хори сүбэчид алагдсан байдаг. Иймээс “Энэ мэт цусаа гаргагдасу” гэх үг нь “энэ мэт өөрөө цусаа гаргая” гэсэн утгатай биш, харин “бусад хүмүүнд энэ мэт цусаа гаргагдаж үхье” гэх утгатай учраас энэхүү өгүүлбэр нь өөртөө үйлдэгдэх хэвд (middle voice) тооцогдохгүй, үйлдэгдэх хэвд тооцогдно.

- [үйлийг хүлээгч indirect-NOM] + үйлийг хүлээгч-ACC-GEN + Vi-PASS

edö'e kö'ü-ben üjeju mawui setki'esü ene metü cisu-ban qarqaqdasu ke'en (МНТ, §178)

Дор өөр нэг жишээ үзье.

- Cimada teyin ke'ekdejU sarta'ul irgen-e eye-dür-iyen ese oroqdaju morilasu ke'en quyuju ilē'esU (МНТ, §265)

Сэцэнцогтоос энэ бол нийтлэг өөртөө үйлдэгдэх хэв гэж, “ор- бол эс тусах үйл үг, эс тусах үйл үг ерийн байдалд үйлдэгдэх хэвийн дагавар залгадаггүй гэдэг. Орчин цагийн монгол хэлэнд иймэрхүү үйлдэгдэх хэвийг эртний монгол хэлний ёсоор зөв оновчтой илтгэж чадахгүй зөвхөн өөрчлөн илтгэж болно. Sarta'ul irgen bidan-u jöblelgegen-dU ese oroju ”гэж тайлбарлав.²¹ Эртний герег хэлний өөртөө үйлдэгдэх хэвд үйлийг үйлдэгч нь өөрөө үйлийг хүлээгч буюу өөрийн ашиг тусын тул өөрөө хийсэн гэх утгыг илтгэдэг үйлийг заадаг. Энэхүү өгүүлбэрт гол илтгэх гэсэн санаа нь сартуул иргэний үйлийг хүртэгч нь Чингис хаан мөн, харин сартуул иргэн өөрөө биш. Иймээс энэ нь герег хэлний өөртөө үйлдэгдэх хэвээс (middle voice) ялгаатай. Уг өгүүлбэр нь (бид=Чингис хаан) ② чамд тийн хэмээгдэж, ② Сартуул иргэнээ эедээ эс орогдож ② морилсу хэмээн ② гуйж илгээвээс. Энэхүү дөрвөн өгүүлэхүүн бүлгийн хэлний зүйн өгүүлэгдэхүүн нь (бид=Чингис хаан) ② ②-г (бид=Чингис хаан) бол үйлийг хүлээгч, ② ②-д (бид=Чингис хаан) бол үйлийг үйлдэгч мөн. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

№	② Чамд тийн хэмээгдэж	② Сартуул иргэнээ эедээ эс орогдож	② морилсу хэмээн	② гуйж илгээвээс
Үйлийг үйлдэгч	Бурхан	Сартуул иргэн	(бид=Чингис хаан)	(бид=Чингис хаан)
Үйлийг хүлээгч	(Бид=Чингис хаан)	(Бид=Чингис хаан)	Сартуул иргэн	Бурхан

“Эедээ эс орогдож” гэх эс тусах үйл үгийн үйлдэгдэх хэвийн хэлбэржилтийн утгын талаар Зохиолын өмнө хойнох агуулгаас мэдэх нь Чингис хаан уругуд илгээсэнд Сартуул иргэн эс зөвшөөрөв. “Сартуул иргэнээ эедээ эс орогдож” гэх үйлийг Чингис хаан хүртэж, өөрөөр хэлбэл Чингис хаан эсэргээр идэвхи бус байранд орсон байдалтайгаар бичив. Энэ мэт идэвхи бус бүтцээр илэрхийлснээс Чингис хаан хэдийгээр Сартуул иргэнд морилсу хэмээсэн боловч уншигчдад эзэрхэг харгис гэх

²¹ Сэцэнцогт (2012), Монгол хэлний үйл үгийн хэвийн онцлогын тухай, Олон улсын монголч эрдэмтний Х их хурал, УБ, р. 239-240.

сэтгэгдэл төрүүлэхгүй. Хүснэгтээс харж болох нь бүтцийн хувьд идэвхи болон идэвхи бусыг уяалдуулан хэрэглэснээр зохиомж нь товч тодорхой болов. “Алтан товч”, Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлсэн “Монголын нууц товчоо” болон 2004 онд боловсруулсан “Монголын нууц товчоо”-ны сонгомол эхэд “Сартуул иргэнээ эедээ эс орогдож” гэх үгсийг шууд хассан байна. Дээрх задлалтаас мэдэж болох нь энэхүү өгүүлбэр нь өөртөө үйлдэгдэх хэв (middle voice) биш, үйлдэгдэх хэвийн дэд гишүүдэд тооцогдно.

(3) Үйлдэгдэх хэвийн дэд гишүүдийн онцлог

Үйлдэгдэх хэвийн дэд гишүүд нь өгүүлбэрийн бүтэц хэлбэр болон утгын талаар доорхи мэт онцлогтой.

- a. Өгүүлбэрийн бүтцийн талаар үйлдэгдэх хэвийн “эх дүр”-ээс будлиантай. Учир нь хэлний зүйн өгүүлэгдэхүүн нь үйлийг шууд хүлээгч биш. Харин дам хүлээгч байдаг. Үйлийг шууд хүлээгч нь хэлний зүйн өгүүлэгдэхүүний харьяаны объект буюу холбогдол бүхий хэрэг явдал байж болно. Хэлний зүйн өгүүлэгдэхүүн нь зарим тохиолдолд гадаад хүчний нөлөөн дор үйлийг үйлдэгч мөн.

- [үйлийг хүлээгч indirect] + үйлийг хүлээгч-ACC-GEN + үйлдэгч-dative + Vt-PASS

öködei sujiyasu-ban sumun-a tusdaju(MHT, §173)

- [үйлдэгч-NOM] + үйлийг хүлээгч-ACC-GEN + Vi-PASS

edö´e kö´ü-ben üjeju mawui setki´esü ene metü cisu-ban qarqaqdasu ke´en(MHT,§178)

- b. Үйлийн шууд бус хүлээгч, үйлийн шууд хүлээгч, үйлийг үйлдэгч зэрэг нь тогтсон тийн ялгалын хэлбэржилт гэж байхгүй.

- [үйлийг хүлээгч indirect] + [үйлийг хүлээгч indirect]-ablative + үйлдэгч-dative +

үйлийг хүлээгч-ACC + Vt + VR-PASS

qurban merkityeke-ciledü-dece yisügei-ba´atur-a hö´élün -eke-yi buliju abtalāi ke´en (MHT,§111)

- үйлдэгч + ber + object-ACC + үйлийг хүлээгч + Vt-PASS

Tede bölök irgen ber..... barqujin-qo´a nertei ökin-ni qori-tumad-un noyan qorilartai-mergen-ne öktegsen aju´u(MHT,§8)

- үйлийг хүлээгч + үйлдэгч-ACC + Reflexcive-dative + Vi-PASS

yisügei-qan imayi ö´er-dür-iyen irekdejü(MHT,§150)

с. Үйлдэгдэх хэвийн үйл үг нь тусах үйл үг болон эс тусах үйл үг бүр байж болно.

➤ үйлийг хүлээгч + үйлдэгч-dative + Vi-PASS

cinggis-qahaneke-de gürtejü(МНТ, §244)

d. Утгын талаар үйлдэгдэх хэвийн дэд гишүүдийн хэлний зүйн өгүүлэгдэхүүн нь үйлийг шууд хүлээгч биш, үйлийг шууд хүлээгч нь хэлний зүйн өгүүлэгдэхүүний харьяаны объект буюу холбогдол бүхий хэрэг явдал байж болно. Хэлний зүйн өгүүлэгдэхүүн нь зарим тохиолдолд гадаад хүчний нөлөөн дор үйлийг үйлдэгч мөн.

➤ [үйлийг хүлээгч indirect-NOM] + үйлийг хүлээгч-ACC-GEN + Vi-PASS

edö'e kö'ü-ben üjejü mawui setki'esü ene metü cisu-ban qarqaqdasu ke'en(МНТ, §178)

e. Үйлдэгдэх хэвийн дэд гишүүдийн утга нь үйлдэгдэх хэвийн “эх дүр”-ийн утгаас будлиантай, зарим өгүүлбэрийг заавал өгүүлэмжийн түвшинд тухайн түүхийн ахуй орчинд авч үзвэл түүний үйлдэгдэх хэвийн утга нь бүрэн ойлгогдоно.

Дээр задалсан мэтээр үйлдэгдэх хэвийн дэд гишүүдийн бүтэц болон утга нь үйлдэгдэх хэвийн “эх дүр”-ээс будлиантай боловч, үндсэн утга үүрэг нь адилхан учир үйлдэгдэх хэвийн айд багтаан судалж сурч эзэмшвэл зүйтэй гэх дүгнэлтэд хүрэв.

НОМЗҮЙ

[1] 札奇斯欽.《蒙古秘史》新譯並註釋[M]..台北:聯經出版社. 1979.

[2] Сэцэнцогт. Монгол хэлний үйл үгийн хэвийн онцлогын тухай[J]. Олон улсын монголч эрдэмтний X их хурал. УБ. 2012

[3] Ш.Лувсанвандан. Орчин Цагийн Монгол Хэл[M]..УБ.2010.

[4] (波)W.科特维奇著,哈斯译.阿尔泰诸语言研究[M]. 内蒙古教育出版社. 2004.

[5] Г.Д.Санжеев. Монгол хэлнүүдийн харьцуулсан хэлзүй[M].Москва. 1963.

[6] Чэнгэлтэй. Одоо үеийн монгол хэлний зүй[M]. Хөххот.2010.

[7] R.R.K. Hartmann ., F.C. Stork.Dictionary of Language and Linguistics(Хятад орчуулга)[M].London: Applied Science Publishers 1972.

[8] Kemmer., Suzanne.The Middle Voice[M]..San Diego : John Benjamins Publishing Company.1993.

[9] Lyons;J. Introduction to Theoretical Linguistics[M].Cambridge University Press.1969.

[10] Ч.Сэцэн. Монгол хэлний үйлдэгдэх хэвд гарсан гурван хувиралт. Монгол хэл бичиг, Хөххот.1996.

[11] Garudi. Dumdadu jaGun-u üy-e-yin mongGol kelen deki -qda/-qde~ -da/-de

kelberi[J].MKUJ:3.1987.

[12] D.Tumurtoogoo (ed) . The Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII-XVI Centuries): Introduction.Transcription and Bibliography[M].Taipei. Taiwan : Institute of Linguistics, Academia Sinica. 2006.

[13] Н.Нансалмаа ; С.Долгор.Танихуйн хэл шинжлэл[М].УБ.Соёмбо принтинг,2014.

[14] Д. Заяабаатар.ХIII-XVI зууны Монгол бичгийн дурсгалын авиазүй, үгзүйн тогтолцоо[M].УБ.2011

[15] Ungerer, F., H.J.Schmid. An Introduction to Cognitive Linguistics [M]. Beijing Foreign Language Teaching and Research Press, 2001.

[16] Taylor, John R. Cognitive models of Polysemy. In Polysemy: Flexible Patterns of Meaning in Mind and Language [M]. (ed.)by Brigitte Nerlich.Zazie Todd , Vimala Herman , David D. Clarke. Berlin; New York: Mouton de Gruyter 2003.

[17] Rosch, E., Mervis, C. B. Family resemblances: Studies in the internal structure of categories[J]. Cognitive Psychology, 1975.

[18] Langacker Ronald. Cognitive Grammar: A Basic Introduction[M]. New York: Oxford University Press, 2008.

[19] Chomsky , N .Syntactic Structures [M] .The Hague :Mouton .1957.

ABSTRACT

On the synchronic term, passive marks have experienced grammaticalization process from “concretion” to “abstraction”, showing a certain development rule. This paper adopts grammaticalization theory to explore Mongolian passive markers process and promotes Mongolian adjective suffixes “-t- (-tai) ” which is used frequently, have gradually transformed in to verb suffixes “-ta/-te~-da/-de” in the appropriate syntactic environment and have been further evolved in to the passive form.